



**“Нийслэлийн өмчит
Улаанбаатар хөрөнгө оруулалт,
менежмент ҮЦК” ХХК**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК”ХХК (цаашид НӨУБХОМ ҮЦК ХХК гэх)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хянаж баталсан болно.

Үнэлгээний бүтэц:

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь нийт 36 асуулга бүхий дараах 9 зарчим бүхий тайлан байна. Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт;
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг;
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал;
4. Аудит, хяналтын тогтолцоо;
5. Эрсдэлийн удирдлага;
6. Эрх бүхий албан тушаалтны цалин, нэмэгдэл;
7. Оролцогч талуудын эрх ашиг;
8. Компанийн соёл;
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх.

Үнэлгээний аргачлал:

Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулав.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсэж болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Асуулгын бүтэц	Авбал зохиx оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин, нэмэгдэл	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
Нэгдсэн дүн		72	72		100%

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 02/02 тоот тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журам батлагдсан. Компанийн дүрмийн 6 дугаар зүйл, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлд ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлага, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн үүрэг хариуцлага, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг хариуцлага, ТУЗ-ийн даргын үүрэг хариуцлагыг нарийвчлан тусгасан. 2025.06.19-ны өдрийн 02/02 тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг нэгдүгээр хавсралтаар, хоёрдугаар хавсралтаар Ёс зүйн дүрмийг баталсан.	2	100%
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгаасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох, нэр дэвшүүлэх зохицуулалтыг тусгасан. ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Компанийн залгамж халааны бодлого” батлагдсан.	2	100%
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр	Бүрэн хэрэгжсэн	Компанийн цахим хуудсанд ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга, мэдээлэл, хурлын ирц, шийдсэн асуудлуудын тухай байршуулсан байдаг. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд дээрх мэдээллүүдийг тусгаж өөрийн цахим хуудсанд https://www.ubim.mn/d/s/1 байршуулсан. Энэ тайланд 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн гишүүд болон хороодын үйл ажиллагааны	2	100%

	тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.		үнэлгээ, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлын тайланг гаргасан.		
4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрмийн 6 дугаар зүйл, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ийн хороодын бүтэц, чиг үүрэг болон ТУЗ-ийн дарга, гишүүдэд тавигдах шаардлагыг тусгасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Аудитын хорооны дүрэм батлах тухай” 05/06 дугаар тогтоолыг Аудитын хороо үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Компанийн залгамж халааны бодлого”, тавдугаар хавсралтаар “Ноогдол ашгийн бодлого”, долоодугаар хавсралтаар “Компанийн цалин хөлс, гүйцэтгэл, үр дүнгийн нэмэгдлийн бодлого” тус тус батлагдсан.	2	100%
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжсэн	Шинээр томилогдсон гишүүдийг компанийн засаглалын сургалтад хамруулдаг бөгөөд өөрчлөлт шинэчлэлт хийгдсэн үед сургалтад хамруулан ажилладаг. ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/07 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар “Шинээр томилогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чиглүүлэх сургалтын хөтөлбөр” батлагдсан. Компанийн жил бүрийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталдаг бөгөөд ТУЗ-ийн гишүүдэд зориулсан сургалтууд 2025 оны төлөвлөгөөнд багтсан. 2025 оны ТУЗ-ийн гишүүд болон нарийн бичгийн дарга МҮЦАЭХ-ны сургалтад, “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн СТРАТЕГИ-101” сургалтад тус тус хамруулсан.	2	100%

6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрмийн 6 дугаар зүйл, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 6 дугаар зүйлд тусгасан. ТУЗ-ийн даргын чиг үүргийн дор ажлын албаны үүргийг хариуцдаг.	2	100%
Дүн				12	100%
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.					
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2-д болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.1-д ТУЗ нь 9 гишүүнтэй, тэдгээрийн 1/3-ээс доошгүй гишүүн нь хараат бус гишүүн байхаар тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэх талаар Үйл ажиллагаа, комплайнсын газар холбогдох хяналт, шалгалтыг гүйцэтгэж дүгнэлт гаргасан. Тухайн дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсан ба холбогдох саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн болно.	2	100%
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.2-д, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.6-д Аудитын хорооны чиг үүргийг тусгасан. Мөн ТУЗ-өөр батлагдсан Аудитын хорооны дүрэмтэй, Аудитын хорооны дарга хараат бус гишүүн ажиллаж байна. Мөн Аудитын хорооны дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-д аудитын хорооны хуралд хорооны даргын зөвшөөрлөөр гүйцэтгэх удирдлага болон ажилтныг оролцуулна гэж заасан байдаг.	2	100%

	хүсэлтээр оролцоно.				
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.8.3-д, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр бүлгийн 4.1-д Цалин урамшууллын хорооны чиг үүргийг тусгасан. ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/06 дугаар тогтоолын долоодугаар хавсралтаар “Компанийн цалин хөлс, гүйцэтгэл, үр дүнгийн нэмэгдлийн бодлого” батлагдсан.	2	100%
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.1-д, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.7-д Нэр дэвшүүлэх хорооны чиг үүргийг тусгасан бөгөөд 3 хараат бус гишүүнтэйгээр ажиллаж байна ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Компанийн залгамж халааны бодлого” батлагдсан.	2	100%
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий	Бүрэн хэрэгжсэн	Компанийн ТУЗ нь Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын гэсэн 3 хороотой мөн ТУЗ-ийн дэргэд Хөрөнгө оруулалтын зөвлөлтэй бөгөөд тус зөвлөл нь Компанийн “Хөрөнгө оруулалтын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын хүрээнд ажилладаг.	2	100%

	бүрэлдэхүүнтэй байна.				
Дүн				10	100 %
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.					
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын 6 дүгээр бүлгийн 6.8-т ТУЗ-ийн нарийн бичгийн даргын чиг үүрэгт Харилцаа холбоо, ил тод байдлын чиглэлээр хэрхэн ажиллах талаар тусгасан. ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/06 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар “Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам” батлагдсан.	2	100%
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн засаглалын кодексийн дагуу ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/07, 04/08 дугаар тогтоолуудаар засаглалын үйл ажиллагааны дотоод баримт бичгүүдийг баталсан. Компанийн цахим хуудаст Ил тод байдал гэсэн цэстэй бөгөөд холбогдох тайлан мэдээ, баримт бичгүүдийг байршуулсан.	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн засаглалын кодексийн сургалт, БОНЗ, IA, Мэдээллийн аюулгүй байдлын сургалт, Эрсдэлийн менежмент, Архив, албан хэрэг хөтлөлт зэрэг сургалтад нийт ажилтнуудыг хамруулсан талаар компанийн 2025 оны тайланд дурьдсан байна.	2	100%
Дүн				6	100 %
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.					

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.6.15-д Аудитын хорооны чиг үүрэгт хөндлөнгийн аудитын байгууллагатай ажиллах чиг үүргийг тусгасан. ТУЗ-ийн баталсан Аудитын хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.9-д Хөндлөнгийн аудитын бие даасан байдлыг баталгаажуулах, хянах гэсэн заалтуудыг тусгасан байдаг. Мөн 2025 оны байдлаар ТУЗ-ийн Аудитын хорооноос хөндлөнгийн мэргэшсэн шинжээчээр “Төсөл хөтөлбөрүүдэд хяналт, шалгалт хийх гэрээний хэрэгжилт, үр дүнгийн тайлан” дүгнэлтийг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, өгсөн зөвлөмжийг биелүүлсэн.	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.6.16-д Хөндлөнгийн аудиторыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулах, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах боломжийг хангана хэмээн Аудитын хорооны чиг үүрэгт тусгасан.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн 2025 жилийн үйл ажиллагааны тайланг өөрийн https://www.ubim.mn/d/s/2 сайтад байршуулсан. Мөн ТУЗ-ийн хурлаар батлагдсан Аудитын хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2	100%
Дүн				6	100%
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн,	Бүрэн хэрэгжсэн	Компанийн бүтцэд Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын албатайгаар ажиллаж байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4.6-д дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын	2	100%

	хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.		талаар аудитын хорооны чиг үүрэгт тусгасан байдаг. ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/08 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар “Үйл ажиллагааны эрсдэлийн журам” батлагдсан. Мөн Гүйцэтгэх захирлын баталсан Эрсдэл ба боломжийг удирдах журам болон Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.		
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь компанийн Дотоод хяналт, эрсдэлийн албаар дамжуулан хяналт, эрсдэлийн тогтолцоог сайжруулан тайлан, дүгнэлт гарган ажилладаг. Мөн компанийн Эрсдэлийн зөвлөл нийт таван гишүүн, нэг нарийн бичигтэйгээр ажиллаж байна. Мөн Гүйцэтгэх захирлын тушаалаар Эрсдэлийн зөвлөлийн үйл ажиллагааны журамтай батлагдсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Эрсдэлийн зөвлөлийн үйл ажиллагааны журмыг 2022 онд Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан.	2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг тодорхойлж үнэлэн, хариу арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулан ажилладаг. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусган, өөрийн сайтад байршуулсан. Мөн 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор Эрсдэлийн үйл ажиллагааны журмыг батлан, хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус	Бүрэн хэрэгжсэн	Компани нь Үйл ажиллагаа, комплайнсын газартай бөгөөд газрын даргын Албан тушаалын тодорхойлолтод комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан. Мөн Гүйцэтгэх захирлын баталсан Комплайнсын үйл ажиллагааны журам болон Комплайнсын	2	100%

	байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.		хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.		
Дүн				8	100%
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.					
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.8.1-д ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс, урамшууллыг шийдвэрлүүлэх; хэмээн тусгасан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн ажилтны цалингийн дээд хэмжээг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд Гүйцэтгэх захирлын баталсан Гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/07 дугаар тогтоолын долоодугаар хавсралтаар “Компанийн цалин хөлс, нэмэгдлийн бодлого” баталсан ба 2024.10.23-ны ТУЗ-ийн тогтоолын хавсралт №2-р үндсэн цалин хөлсний шатлалд өөрчлөлт оруулсан.	2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хооронд байгуулсан гэрээнд цалин, урамшууллын хэмжээг тусгайлан заасан байдаг. Тухайн жил бүр зорилтот түвшнийг ТУЗ-өөр баталгаажуулан гэрээнд хавсралтаар оруулдаг. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланд Төлөөлөн удирдах зөвлөл БҮРЭН ХАНГАЛТТАЙ дүгнэлт өгсөн.	2	100%
Дүн				6	100%
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.					
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/07 дугаар тогтоолын зургаадугаар хавсралтаар “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого” батлагдсан.	2	100%

	ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.				
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний Зорилт 3-ийн хүрээнд “Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан, Сангийн яам болон Нийслэлийн засаг даргын тамгын газрын холбогдох нэгжийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх Улаанбаатар хотын “Төлбөрийн чадварт нийцсэн, ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэлийн салбарын төсөл”-ийг Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК-тай хамтран хэрэгжүүлэх” гэж төлөвлөсөн ба төслийг амжилттай хэрэгжүүлж байна.	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн олон нийттэй харилцах сүлжээ болох https://www.ubim.mn , https://www.facebook.com/ubim.mn цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээ мэдээлэл, ажлын байрны зарууд, үйл ажиллагааны болон засаглалын тайлангууд, шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга болон бусад мэдээллүүдийг олон нийтэд мэдээлж ажиллаж байна. 2025 онд цахим хуудсыг шинэчлэн шинэ хувилбар гаргаж идэвхжүүлэн Хөрөнгө оруулагчдад болон бусад оролцогчдод зориулсан компанийн үйл ажиллагаа болон хийгдэж байгаа ажлуудын мэдээллийг тогтмол оруулан ажиллаж байна.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод	Бүрэн хэрэгжсэн	Компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор гаргасан харилцагч болон ажилтнуудын санал, гомдлыг хүлээн авах, бүртгэх, барагдуулах, шийдвэрлэх, холбогдох сайжруулалтыг хийхтэй холбоотой харилцааг зохицуулах “Санал, гомдол шийдвэрлэх	2	100%

	журам, ажлын төлөвлөгөөтэй байна.		журам”, “Кайзен саналыг хэрэгжүүлэх, үнэлэх журам” хэрэгжүүлж байна, ажилтнуудын мэдлэг, ур чадварын түвшнийг нэмэгдүүлэх, шинэ ажилтанд холбогдох дүрэм журам, стандартуудыг таниулах, сургалтын үр өгөөжийг тооцох, сургалтын тайлан, бүртгэлийг хийх харилцааг зохицуулах “Сургалт хөгжлийн журам”-г үйл ажиллагаандаа 2022.08.19-ны өдрөөс хэрэгжүүлж мөрдөн ажиллаж байна. Мөн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлон шаардлагатай ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулан Гүйцэтгэх захирлаар батлуулж хэрэгжилтийг ханган ажилладаг.		
Дүн				8	100%
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/08 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг тогтоож, түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах “Ёс зүйн дүрэм” батлагдсан бөгөөд ТУЗ-ийн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 02/02 дугаар тогтоолоор ёс зүйн дүрмийг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Компанийн цахим хуудсанд алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг байршуулсан. Мөн 2025-2028 оны Стратеги төлөвлөгөөнд компанийн алсын хараа, эрхэм зорилго болон үнэт зүйлсийг баталсан.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн”	Бүрэн хэрэгжсэн	Компанийн “Ёс зүйн дүрэм”, “Комплайнсын үйл ажиллагааны журам”-д шүгэл үлээгчийн тогтолцоог тусгасан.	2	100%

	тогтолцоотой байна.				
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжсэн	Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.5-д Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэх чиглэлээр дараах үйлдэл, эс үйлдэл гаргахыг хориглоно хэмээн тусгасан.	2	100%
Дүн				6	100%
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.					
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжсэн	Компани сарын төсвийн гүйцэтгэл, улирал, бүтэн жилийн санхүүгийн тайлан гарган Нийслэлийн өмч ашиглалт удирдлагын газар, Нийслэлийн төрийн сан, НИТХ-д хүргүүлдэг бөгөөд www.shilendans.gov.mn -д шилэн дансны мэдээ тайлагнан ажилладаг. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг долоо хоног, сар, улирал, бүтэн жилээр гарган НЗДТГ-т тайлагнан ажиллаж байна. Мөн гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/14 тоот тушаалаар батлагдсан “Гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний журам”-ыг мөрдөн ажилладаг.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/07 дугаар тогтоолын зургаадугаар хавсралтаар “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого” батлагдсан. Компанийн цахим хуудсанд хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалт хүсэгч нарт зориулсан цэс, олон нийттэй харилцах сүлжээнд үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг оруулан ажиллаж байна. https://www.ubim.mn/investment	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах	Бүрэн хэрэгжсэн	Компанийн дүрмийн 5 дугаар зүйл, “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 2.1.9 болон 9.8.3-т тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	100%

	зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.				
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжсэн	“Компанийн дүрэм”-ийн 4 дүгээр зүйлд заасан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжсэн	ТУЗ-ийн 2022.12.22-ны өдрийн 04/08 тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам” батлагдсан бөгөөд 2025 оны байдлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй байна.	2	100%
Дүн				10	100%
НЭГДСЭН ДҮН				72	100%

Манай компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг НИТХ-ын 2025 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн 25/33 дугаар тогтоолоор шинэчилж, хороод, хараат бус гишүүдийг томилсон бөгөөд, 2025 оны 12 сарын 08-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар Лхагвасүрэн овогтой Цолмонтуяаг томилсон болно.

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:
ТУЗ-ИЙН ДАРГА

Л.ХОСБАЯР

ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Л.ЦОЛМОНТУЯА



2025 оны 12 дугаар сарын 29-ний өдөр